



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Тэшиг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/23/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас:7034-2580 Цахим хаяг: [Bulgan@audit.gov.mn](mailto:Bulgan@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас:9905-7478 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас:9907-9641 Цахим хаяг: [Tserenlhamg@audit.gov.mn](mailto:Tserenlhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 20

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

ТЭШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.БАТСАЙХАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх зүйн шийдвэргүйгээр 1-3 хувиар нэмэгдүүлэн 0.5 сая төгрөгийн илүү цалин олгосон, уралдаан тэмцээнд шагнал урамшууллын 5.3 сая төгрөгийн зардлыг суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод суутгасан АТТайлан ТТ-12 тайлагнаагүй, Засаг даргын хувийн харилцах дансанд нийт 1.6 сая төгрөгийн гутал, шатахууны зардлыг шилжүүлсэн,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 43 удаагийн гүйлгээгээр шатахуун, хоол, хүнсний материал, шагнал урамшуулал, сэлбэгийн нийт 17.7 сая төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчин зориулалт бусаар зарцуулсан,
- Бичиг хэргийн материал дансанд тамга, тэмдэг, хуулбар үнэн тэмдэг, цоож, баримт үдэгч, ном зэрэг аж ахуйн болон үндсэн хөрөнгийн шинж чанартай, зарцуулсан материалыг зарлагадаагүй, дансны ангилал зөрчиж 24.5 сая төгрөгийн материал бүртгэсэн,
- Барилга байгууламж дансанд 362.3 сая төгрөгийн 27 худаг бүртгэлтэй

6326050244

байгаагаас, 135.2 сая төгрөгийн 6 худаг ашиглалтгүй, 13.0 сая төгрөгийн Жаргалант, 5 дугаар багт байршилтай худгийг Хилийн цэргийн 0286 дугаар ангид зөвшөөрөлгүй ашиглуулсан,

- Төрийн өмчийг иргэнтэй гэрээгүй, зөвшөөрөлгүй сумын айл өрх, хуулийн этгээд, байгууллагын хог хаягдлыг тээвэрлүүлэх зорилгоор "Кама" ачааны автомашиныг ашиглуулсан,
- 5312БУА улсын дугаартай автомашины марк зөрүүтэй, тээврийн хэрэгслүүдийг даатгалд хамруулаагүй, торгууль болон замын хураамж төлөөгүй, тээврийн хэрэгслийн хувийн хэргийн бүрдүүлэлт, нотломж хангалтгүй,
- "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ-т ашиглагдаж байгаа ухаалаг худаг 15.0 сая, цэвэрлэх байгууламж тоног төхөөрөмж 150.0 сая, халаалтын зуух тогоо 878.2 сая, уурын зуухны өргөтгөл 19.0 сая төгрөгийн хөрөнгүүд бүртгэлтэй, мөн байгууламжийг тоног төхөөрөмжөөр бүртгэж, элэгдлийг буруу байгуулсан,
- Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгөө нөхсөн 7,476.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1, 2.2 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн хөгжлийн сангаас "Тэшигийн сэргэлт" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хөл бөмбөгийн талбай, төвийн 04кв шугамын шинэчлэл, гэрэлтүүлэг, бэлчээрийн болон ухаалаг худаг, тэжээлийн тоног төхөөрөмж нийт 583.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч бүртгэж тайлагнасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792 мянган төгрөг болгосон, ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square stamp containing a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style. The stamp also contains Mongolian text in red, which is partially obscured by the signature.

Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	127,594.1	111,134.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,486,454.1	2,977,507.3
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,614,048.2</b>	<b>3,088,641.9</b>
Нийт өр төлбөрийн дүн	736,500.3	741,650.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,877,547.9	2,346,991.6
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,614,048.2</b>	<b>3,088,641.9</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,203,455.2	1,911,276.3
Үйл ажиллагааны зардлын дүн	1,528,744.2	1,441,832.7
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>674,711.0</b>	<b>469,443.6</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>674,711.0</b>	<b>469,443.6</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,202,836.9	1,877,547.9
Тайлант оны үр дүн	674,711.0	469,443.6
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,877,547.9</b>	<b>2,346,991.5</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,407,222.9	1,390,357.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,382,357.9	1,220,657.5
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>24,865.0</b>	<b>169,700.0</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(24,865.0)</b>	<b>(169,700.0)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	-	<b>1,104,789.6</b>
Урсгал зардал	-	1,025,089.6
Хөрөнгийн зардал	-	79,700.0
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	-	<b>1,104,789.6</b>
Улсын төсвөөс санхүүжих	-	1,103,154.1
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	1,635.5

## Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэшиг сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан, шуурхай, чанартай хүргэж, төрийн захиргааны манлайлагч байгууллага байх нь бидний эрхэм зорилго” гэж тодорхойлсон байна. Харин 2025 оныг “Тогтвортой хөгжил, хариуцлагатай төрийн алба” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхээр “Хутаг-Өндөрийн сэргэлт” засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дараах зорилтыг хүрээнд ажилласан байна

“Тэшигийн сэргэлт” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хүний хөгжлийн бодлого, Эдийн засаг, Ногоон хөгжил, Дэд бүтэц, Засаглалын бодлого, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс орон нутгийн бодлого гэсэн арга хэмжээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, сумын Засаг даргын 2025 оны А/439 дүгээр захирамжаар 87.5 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Авилгын эсрэг хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, тогтоомж, Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хууль,
- Сумын ИТХ-ын холбогдох тогтоолууд,
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ. Тайлант онд хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан,

Хойд бүсийн хөгжлийн чуулган, Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг Булган аймагт зохион байгуулсан.

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792.0 мянган төгрөг болгосон, ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

### **Тав. Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн хөгжлийн сангаас "Тэшигийн сэргэлт" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хөл бөмбөгийн талбай, төвийн 04кв шугамын шинэчлэл, гэрэлтүүлэг, бэлчээрийн болон ухаалаг худаг, тэжээлийн тоног төхөөрөмж нийт 583.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч бүртгэж тайлагнасан байна.

### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

#### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 178 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл тус бүрийн хавсралт файл буюу нотлох баримтыг мэдээлээгүй, байгууллагын ерөнхий мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

#### **Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**Илрүүлэлт 1:** Архив албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан хийж ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20

дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын албан тоот, тушаал гэх мэт хэвлэмэл болон улсын байцаагчийн үнэт цаасыг бодитоор тоолж, тайланг хариуцсан ажилтнаар гаргуулж хэвших зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Гадаад албан томилолтын зардлыг зардлын эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулсан эсэх, анхны өртгөөрөө элэгдлээ нөхсөн үндсэн хөрөнгө, дансны ангилал, хөтөлбөр арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд цэргийн штабын санхүүгийн тайлан төсвийн шууд захирагчаар тайлагнагдсан эсэх, 2023 оны санхүүгийн жилд ХХААГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан оёдлын үйлдвэрийг дэмжих зорилгоор олгосон 40.0 сая төгрөгийн зориулалт бус зарцуулалтад гаргасан аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **Найм. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 226.3 сая төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 226.3 сая төгрөгийн алдааг бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 729.6 сая төгрөгийн 12 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 25.8 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 262.8 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 441.0 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 729.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 631.1 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### **Төлбөрийн акт**

**Илрүүлэлт 1:** Жолоочийн тооцооны хуудсаар шатахуун зарцуулалтыг бодоогүй, спидометрийн заалт зөрүүтэй, хяналт, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1, Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Жишиг норм батлах тухай” журамтай нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

**Шийдвэрлэсэн нь:** Жолоочийн тооцооны хуудасгүй, норм нормативаас хэтрүүлэн зарцуулсан 1.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт 2:** Төсвийн хэмнэлтийн зарчмыг хэрэгжүүлээгүй, айраг фестиваль-2025 арга хэмжээнд зочин төлөөлөгч хүлээн авалт, ус, ундааг зах зээлийн үнээс хэт өндөр дүнгээр худалдан авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" зэрэг эрх зүйн шийдвэрүүдтэй зөрчилдөж, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хүлээн авалтын арга хэмжээнд зарцуулсан 8.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт 3:** Төсвийн хэмнэлтийн зарчмыг хэрэгжүүлээгүй, хойд бүсийн зөвлөгөөнд согтууруулах ундааны зүйлийг нийт 9.8 сая төгрөгөөр худалдан авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" зэрэг эрх зүйн шийдвэрүүдтэй зөрчилдөж, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундааны зүйл худалдаж авсан 9.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт 4:** Төсвийн хэмнэлтийн зарчмыг хэрэгжүүлээгүй, албан тушаалын 2 орон сууцанд гал тогооны тавилга 5.4 сая төгрөгөөр худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой зөрчилдөж, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хөрөнгөөр албан тушаалын байр тохижуулсан 5.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

## Албан шаардлага

**Илрүүлэлт 1:** Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос нэр бүхий 7 албан тушаалтанд идэвх, санаачилгатай ажилласан гэх нотлох баримтгүй, аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар урамшуулал 3.5 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1.9 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нэр бүхий албан тушаалтанд зориулалт бусаар урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2:** Засаг даргын нөөц сан, хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэх зардлаас 54.4 сая төгрөгийг нярвын харилцах дансанд шилжүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гэрээ байгуулаагүй, хувийн харилцах дансанд шилжүүлэн бэлэн мөнгө авч зарцуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 3:** Цэргийн дүйцүүлэх албаны батлагдсан тээвэр, шатахууны зардлын төсвийг хэтрүүлсэн, аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн дансны гүйлгээг цаг хугацааны дэс дарааллаар ажил гүйлгээ бүрээр бус бөөн дүнгээр нийт 13.8 сая төгрөгийг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1.9 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажил гүйлгээг цаг хугацааны дэс дарааллаар бус бөөн дүнгээр ерөнхий журналд бүртгэсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 4:** Хялганат тосгоны ЗАА, Баян-Агт сум, Орхон сумын ЗДТГ, Булган сумын 1-р сургууль, Бүрэгхангай сум, Хутаг-Өндөр сумын ЕБС, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв, АТҮТ-ийн Булган салбарт Засаг даргын нөөц хөрөнгөөс ой тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд нийт 77.0 сая төгрөгийг хандивласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нэр бүхий албан тушаалтанд зориулалт бусаар урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 5:** "АЙРАГ ФЕСТИВАЛЬ-2025" эвэнт арга хэмжээний урлагийн наадам шоуны гүйцэтгэгчийг сонгохдоо худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, "B SOUND PRODUCTION"-тай шууд гэрээ байгуулан, 4 удаагийн гүйлгээгээр 75.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 18 дугаар зүйлийн 18.1-т заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нэр бүхий албан тушаалтанд зориулалт бусаар урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 6:** Нутгийн удирдлагын ордны гадна 10 метр өндөртэй сүлд мод, чимэглэлийг "Гангантөгс трейд" ХХК, "Хашака" ХХК-иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 39.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 18 дугаар зүйлийн 18.1-т заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нэр бүхий албан тушаалтанд зориулалт бусаар урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

## **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт 1:** Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж дансанд 12 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацаанд 0, -1 гэж утгаар оруулснаас тайлант хугацааны элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар зүйл, ТӨБЗГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам" 2019 оны 271 дүгээр тогтоол, Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны 8 дугаар хуралдааны 55 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** УСНББОУС-38-ийн биет бус хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурт нийцсэн хөрөнгийг биет бус хөрөнгөөр бүртгэж байх.

**Илрүүлэлт 2:** Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 278 нэр төрлийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар зүйл, ТӨБЗГ-ын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам" 2019 оны 271 дүгээр тогтоол, Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны 8 дугаар хуралдааны 55 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Загруулсан	Загруулаагүй	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг илүү тайлагнасан.	1	549.7			1	549.7	1	549.7		
Үндсэн хөрөнгийн тодруулаа тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг илүү тайлагнасан, мал амьтан дансанд бусад хөрөнгийг бүртгэсэн.	1	577.5			1	577.5	1	577.5		
Уралдаан тэмцээнд шагнал урамшуулал олгосон шагналын суутгалыг шагнал авсан хүмүүсээр бус, арга хэмжээ зохион байгуулсан албан хаагчид олгосон хэлбэрээр суутган төлөчийн хувь хүнд олгосон орлогод суутгасан АТТайлан ТТ-12 буруу тайлагнасан.	1	5.3			1	5.3	1	5.3		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,132.5</b>			<b>3</b>	<b>1,132.5</b>	<b>3</b>	<b>1,132.5</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс					
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны Тоо	Тоо	Дүн
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх зүйн шийдвэрлүүлгээр 1-2 хувиар нэмэгдүүлэн олгосон байна. Сумын Засаг дарга гамшгийн сургалтад хэрэглэгдэх хоёр ширхэг гүтгэн өөрийн хувийн харилцах дансанд авч, бараа нийлүүлсэн байна.	1	0.6			1	0.6							
Иргэн, хуулийн этгээдтэй ашиглалтгүй гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй Хиллийн цэргийн 0286 дугаар анги 1 худал, кама ачааны автомашиныг иргэн ашиглаж байна.	1	19.0					1	19.0					
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 62 нэр төрлийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	7,476.9					1	7,476.9					
Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдэлд ашиглалтгүй барилга байгууламж дансанд 6 худал, 5084БУЛ улсын дугаартай ланд-105 автомашин байна.	1	76.5					1	76.5					
Хужирт багт байршилтай ЕБС-ийн сургуулийн дотуур байрны их засварыг нэмж 1 барилгаар бүртгэж, 2 барилга бүртгэлтэй байна.	1	23.1					1	23.1					
Тэйшиг-Ус ОНӨААТҮГ-азарт ашиглагдаж байгаа ухаалаг худал 15.0 сая, цэвэрлэх байгууламж тоног төхөөрөмж 150.0 сая, халаалтын зуух тогоо 878.2 сая, уурын зуухны өрөгтөл 19.0 сая төгрөгийн хөрөнгүүд бүртгэлтэй, мөн байгууламжийг тоног төхөөрөмжөөр бүртгэж, элэгдлийн зардлыг буруу байгуулсан байна.	1	1,047.2					1	1,047.2					
Тоног төхөөрөмж дансанд 234 кодтой 9.3 сая төгрөгийн камер, 268 кодтой 16.0 сая төгрөгийн сумын төвийн гэрэлтүүлэг, 11 нэгж талбарын газрын хэмжээ байхгүй 1 гэсэн тоон үзүүлэлтээр бүртгэж, ажиг гүйлгээг дутуу тайлагнасан байна.	1	25.3					1	25.3					

Бичиг хэрэгийн материал дансанд тамга, тэмдэг, хуулбар үнэн зэрэг тэмдэг, цоож, баримт үдэгч, ном зэрэг аж ахуйн болон үндсэн хөрөнгийн шинж чанартай, зарцуулсан материалыг зарлагадаагүй, дансны ангилал зөрчиж бүртгэж, тайлагнасан байна.	1	24.5				1	24.5						
	1	17.7				1	17.7						
р гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 43 удаагийн гүйлгээгээр шатахуун, хоол, хүнсний материал, шатнал урамшуулал, сэлбэг худалдан авсан байна.	10	8,712.4	0	0	2	2.2	8	8,710.2	0	0	0	0	0
Дүн													

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс аудалтын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, батлагдсан төсвийг мянган төгрөгөөр мэдээлсэн, байгууллагын ерөнхий мэдээлэл дутуу, хавсралт файлыг холбогдох мэдээллийн нотлох баримтыг дутуу, хангалтгүй мэдээлсэн байна.	1	-						1	-
Дүн	1	-						1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Албан хэрэг хөтлөлтийн үнэт цаасны тайлан гаргаагүй, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, цахим архивын нэгж үүсгэж ажиллаагүй байна.	1	-						1	-
Дүн	1	-						1	-
Нийт дүн	2	-						2	-